

**ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД
ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН ЗАРИМ ШИНЖИЛГЭЭ**
**SOME ANALYSES ON THE LEGAL REGULATION OF
PROSECUTORIAL SUPERVISION OVER THE ENFORCEMENT OF
SENTENCES RESTRICTING THE RIGHT TO TRAVEL**

Ц.Мөнхбат

Судлаач, хууль зүйн ухааны доктор, профессор

Товч утга: Зорчих эрхийг хязгаарлах ялын эрх зүйн зохицуулалтыг тусгасан хууль тогтоомж болон түүний хэрэгжилтэд хяналт тавих эрх зүйн үндэслэл болсон прокурорын хяналтын аргачилсан зааврыг харьцуулан судалж, тэдгээрийн нийцэл, уялдаа холбоо, цаашид анхаарах асуудлыг тодруулсан болно.

Түлхүүр үг: Үндсэн хууль, хууль тогтоомж, прокурорын хяналт, зорчих эрхийг хязгаарлах ял, зөрчилдөөн, аргачилсан заавар

Abstract: This study comparatively examines the legal regulations concerning the punishment of restricting the right to travel and the prosecutorial supervisory procedural guidelines that serve as the legal basis for monitoring their implementation. It highlights the consistency and interrelation between these regulations and identifies issues that require further attention moving forward.

Key words: Constitution, legislation, prosecutorial supervision, sentence restricting the right to travel, conflict, procedural guidelines

УДИРТГАЛ

Үндсэн хуульд зааснаар прокурор ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих (Үндсэн хууль, 1992) ба үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлж гаргасан хуулийг баримталж, орон нутаг, салбар, байгууллагын онцлогийг үл харгалзан хуулийг нэг мөр хэрэглэх явдлыг хангаж (Прокурорын тухай хууль, 2017) ажиллах ба прокурорын үйл ажиллагааг хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, аргачилсан заавраар нарийвчлан зохицуулах (Прокурорын тухай хууль, 2017) хуулийн шаардлагын үүднээс Улсын ерөнхий прокурор 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар “Ял эдлүүлэх ажиллагаанд тавих

прокурорын хяналтын аргачилсан заавар”-ыг баталж мөрдүүлж байгаа ба түүнд эдлүүлэх болон зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулийн заалтыг нэг мөр хэрэгжүүлэх хүний эрх, эрх чөлөөг хангах зөрчигдсөн эрхийг сэргээх, эрүүдэн шүүх явдлыг гаргуулахгүй байхад прокурорын хяналтыг чиглүүлэх, прокурорын шийдвэр, үйл ажиллагаа хуульд нийцсэн байх, хяналт хариуцсан прокурорт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх гэж зорилт, зорилгоо тодорхойлсон байна.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн (Үндсэн хууль, 1992) нэгдүгээр зүйлд “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” хэмээн тунхагласан билээ. Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид багш “Хууль дээдлэх ёс гэдэг бол ... төр нийгмийн хөгжлийн жам ёсыг тусган тухайн улсын Үндсэн хуульд нийцүүлсэн бодит чанартай эрх зүйн үзэл, өөрөөр хэлбэл шударга үнэний хуулиар нийгмийн харилцааг зохицуулсан зарчим мөн. Хууль дээдлэх ёс нь угтаа эрх зүйг дээдлэх гэсэн агуулгатай болно. (Чимид, 2019, хууд. 118) гэж бичсэн байна.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан: “Хуулийн төвд хүн орших учиртай. Хууль хэнийг ч үл ялгаж, эрх тэгш хэрэгжиж, хууль дээдлэх ёс бүрэн тогтох ёстой. Албан тушаалтны үзэмжээр хандах, авлига, хүнд суртал газар авах хөрс болж байгаа журмуудыг үндсээр нь устгаж, хууль дээдлэх зарчмыг бодит утгаар хэрэгжүүлэх цаг ирсэн.... журмыг дураар, үзэмжээр батлах явдлыг таслан зогсоох, ... шинэ харилцааг журмаар зохицуулдаггүй байх шаардлага тавигдаж, журмыг зөвхөн хуульд заасан тохиолдолд, мөн хуулиар тогтоосон хүрээ хязгаарт баталдаг болж, журмаар зохицуулж үл болох буюу зөвхөн хуульд тусгах харилцааны зааг тодорхой болно. (Амарбаясгалан, 2025) гэж Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы нээлтэнд хэлсэн үгэндээ дурдсан байна. Иймд цаг үеийн нөхцөл байдлын хүрээнд дээр дурдсан “Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар”-ыг /цаашид аргачилсан заавар гэх/ зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх процессыг зохицуулсан хууль болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуультай харьцуулсан судалж, судалгааны үр дүнг үндэслэн судлаачийн байр суурь, үнэлэмжээ илэрхийлэхийг зорьсон болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

Эрүүгийн хууль (Эрүүгийн хууль, 2016) зааснаар гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах ялын нэг төрөл болох зорчих эрхийг хязгаарлах ялыг (Эрүүгийн хууль, 2016) гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суугаа газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг 1 сараас 5 жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял (Эрүүгийн хууль, 2016) гэх ба шүүх тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан, ялтныг бусдад аюул учруулах эрсдэлтэй гэж үзвэл тодорхой хүнтэй, бусадтай харилцахыг хориглож болно (Эрүүгийн хууль, 2016) гэж тодорхойлсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль, 2017) 18 дугаар бүлэгт “Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх” процесс ажиллагааг журамласан ба тухайн ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу байгаа эсэхэд прокурорын хяналт зааврын дагуу чиглэгдэж байгаа боловч анхаарал татсан асуудлууд байна. Үүнд:

Нэг. Процессын хуульд (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль, 2017) заасан үндэслэлээр прокурорын зөвшөөрлөөр ахлах шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхэд тогтоосон хориглолт, хязгаарлалтыг 30 хүртэл хоногийн хугацаанд өөрчилж болох ба энэхүү хугацаа дууссан даруйд ялтанд шүүхээс тогтоосон зорчих эрхэд тавьсан хориглолт, хязгаарлалтыг сэргээн тогтоож, ял эдлүүлэх ажиллагааг ердийн журмаар үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. Тэгвэл аргачилсан зааврын 7.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 173 дугаар зүйлд заасан үндэслэл тогтоогдсон бол зөвшөөрлийг **бичгээр** олгоно. Ялтны зорчих эрхэд тогтоосон хориглолт, хязгаарлалтыг түр хугацаагаар өөрчилсөн хугацаа дууссан даруйд прокурор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 173 дугаар зүйлийн 173.2 дахь хэсэгт заасны дагуу шүүхээс тогтоосон зорчих эрхэд тавьсан хориглолт, хязгаарлалтыг сэргээн тогтоох **тогтоол** гаргаж, шийдвэр гүйцэтгэх байгууллагад олгож хүргүүлнэ.” гэжээ. Энд тухайн асуудал нь үндэслэлтэй бол “**Зөвшөөрлийг бичгээр олгож болох**” нь хуульд нийцэж байгаа хэрнээ хугацаа дуусмагц “**Шүүхээс тогтоосон зорчих эрхэд тавьсан хориглолт, хязгаарлалтыг сэргээн**

тогтоох тогтоол” гаргах нь логикийн хувьд ойлгомжгүй байна. Прокурорын зөвшөөрөл болон тогтоол нь “Прокурорын хяналтын эрх зүйн хэлбэр”-ийн төрөл бөгөөд агуулгын хувьд ялгаатай байна. Тухайлбал, Хуульд заасан тохиолдолд прокурор ял эдлүүлэх ажиллагааны явцад зөвшөөрөл олгох (Прокурорын тухай хууль, 2017) бол тогтоолыг чиг үүргээ хэрэгжүүлэхдээ бүрэн эрхэд хамаарах асуудлыг шийдвэрлэхээр (Прокурорын тухай хууль, 2017) гаргадаг байна. Дурдсан тохиолдолд эхлээд хугацаатай зөвшөөрөл олгосон бол хугацаа дуусмагц уг “зөвшөөрөл “автомат”-аар хүчингүй болох ба прокурор биш харин ахлах шийдвэр гүйцэтгэгч **“Шүүхээс тогтоосон зорчих эрхэд тавьсан хориглолт, хязгаарлалтыг сэргээн тогтоох тогтоол”** гаргаж, прокурорт танилцуулах үүрэг хүлээх ёстой юм.

Хоёр. Хуульд зааснаар ялтны зорчих бүсийг ахлах шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн прокурор өөрчилж болох (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль, 2017) ба ялтан ял эдлэх бүсээ өөрчлүүлэх тухай үндэслэл бүхий хүсэлтийг бичгээр гаргах бөгөөд шийдвэр гүйцэтгэгчийн санал, холбогдох материалын (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль, 2017) прокурор хянах үүрэгтэй юм. Харин аргачилсан зааварт бол зөвхөн “шийдвэр гүйцэтгэгчийн санал, хувийн хэргийг хянаж шийдвэрлэх”-ээр заасан нь ахлах шийдвэр гүйцэтгэгчийн санал, ялтны хүсэлтийг орхигдуулсан байна. Нөгөө талаар хуульд “материал” гэсэн байхад аргачилсан зааварт “хувийн хэрэг” гэсэн нь хэр нийцэх вэ. Хуульд заасан нэр томъёонд журам, заавар нийцэх учиртай гэж ойлгож байна.

Гурав. Ялтан ял эдлүүлэх журмыг зөрчөөгүй, өөрийн **зан үйл**, хувийн байдлаараа ял эдлүүлэхэд саад учруулаагүй бол түүнд нэг сард тав хүртэл хоногийн шагналын хоног олгож болн (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль, 2017) гэж хуулчилсан бол аргачилсан зааврын 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Ялтны хувийн байдал, **засрал хүмүүжилд** бодитой дүгнэлт хийсэн эсэх” гэжээ. Энд “**зан үйл**” болон “**засрал хүмүүжил**”-ийн хооронд ялгаа байна уу гэх асуудал үүсэж байна.

Монгол хэлний товч тайлбар бичигт “**Зан**” гэдэг үгийг “**Хүн амьтны аашлах байдал, төлөв, зан ааль** (Цэвэл, 1966, хууд. 265), “**Үйл**” гэснийг “**Хийж явуулах хэрэг явдал**”, “**Засрах**” гэснийг “**Муу муухай байдал нь дээрдэх, сайжрах, засах засамжлах үйлийг биеэрээ дааж авах буюу өөрөө засагдан сайжрах**” гэж тайлбарласан бол Монгол хэлний их тайлбар тольд “**Зан үйл**”-ийг “**Хүний аж амьдралтай уялдан хэвшиж тогтсон**

заншил, түүнтэй холбоотой элдэв үйл хөдлөл (Монгол хэлний их тайлбар толь, 2015) “Хүмүүжил”-ийг “Хүний биеэ авч явах дадлага, чадвар, төлөвшсөн зан чанар, ёс суртахуун, ухамсартай болгон төлөвшүүлэх” гэжээ. Утгын хувьд харьцуулалт хийж үзэхэд “зан үйл” ба “засрал хүмүүжил” ойлголтын хувьд ялгаатай байна.

ДҮГНЭЛТ

Судалгааны үндсэн дээр дараахь дүгнэлтийг хийж болохоор байна. Прокурорын хяналтын аргачилсан заавар нь өгүүллэгийн эхэнд дурдсан зорилт, зорилгоо бүрэн хангаж чадаагүй байна. Агуулгын зарим зүйл заалт нь хуультай зөрчилдсөн байна. Жишээ нь, Ялтны зорчих эрхэд тогтоосон хориглолт, хязгаарлалтыг өөрчлөхөд прокурор зөвхөн зөвшөөрөл олгох үүргийг хуулиар хүлээсэн байхад аргачилсан заавраар уг хориглолт, хязгаарлалтыг сэргээн тогтоохоор тогтоол гаргахаар заасан нь хуулиас давсан заалт гэж үзэж болохоор байна. Энэ нь нөгөө талаар прокурорын ажлын ачааллыг хиймлээр нэмэгдүүлж байгаа хэлбэр юм.

Хуулийн нэр томъёог журам, зааварт өөрөөр буулгаснаар утга, агуулгыг нь гажуудуулж, ойлголтын зөрүү үүсгэсэн байна.

САНАЛ

Дараахь саналыг дэшүүлж байна. Үүнд:

1. Хууль дээдлэх ёс, хуулийг нэг мөр хэрэглэх зарчмыг баримталж, хуулийн хүрээ хязгаарт багтааж нийцүүлэн, аргачилсан зааврыг дахин боловсруулж батлах;
2. Хуулийн нэр томъёоны утга агуулгад ач холбогдол өгч, аргачилсан зааварт тусгахдаа анхаарах;
3. Хуулиас давсан аргачилсан зааврын зүйл заалтыг хүчингүй болгох;
4. Хуульд тодорхой тусгасан зүйл, заалтыг аргачилсан зааварт дахин нурушиж дурдахгүй байх.

Эх сурвалж

Прокурорын тухай хууль, №25 (Төрийн мэдээлэл. Эмхэтгэл 2017).
Чимид, Б. (2019). Төрийг засах ёс. Улаанбаатар.
Амарбаясгалан, Д. (2025, 03 17). Өнөөдөр хууль ба журмын зохистой харьцаа алдагдсаны улмаас хууль биш, харин журам ноёлж байна. Улс төр. Retrieved from iSEE.mn.

Монгол хэлний их тайлбар толь. (2015). Улаанбаатар.

Прокурорын тухай хууль, №24 (Төрийн эмхэтгэл мэдээлэл 2017).

Үндсэн хууль, №1 (Төрийн эмхэтгэл мэдээлэл 1992).

Үндсэн хууль, Төрийн эмхэтгэл мэдээлэл (№1 1992).

Цэвэл, Я. (1966). Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль, №24 (Төрийн эмхэтгэл мэдээлэл 2017).

Эрүүгийн хууль, №7 (Төрийн эмхэтгэл мэдээлэл 2016).